

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД
МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

6-27

**1. Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Оюу толгой бүлэг
ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах,
хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай
шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга
хэмжээний тухай/**

6-27

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 12 дугаар сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр нээлттэй хуралдаан 15 цаг 30 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар;
Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн;
Тасалсан: Д.Пүрэвдаваа.

Нэг.Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Б.Нандингэрэл, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан шинжээч С.Амарбат, Д.Доржнамжил, А.Мөнхбадрал, С.Номин, М.Ихэртөр, Э.Энэрэл, хянан шалгагч Б.Батчимэг, Х.Баярмаа, С.Ганбаатар, Ж.Наранпүрэв, И.Уянга нар оролцов.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир үг хэлэв.

Хянан шалгах түр хорооны хуралдаан 16 цаг 06 минутаас 17 цаг 35 минутад түр завсарлав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ө.Шижир, Б.Жаргалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ө.Шижир, Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал нар үг хэлэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

О.Батнайрамдал: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Уянга нарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга үг хэлэв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 6
Бүгд: 6
0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу иргэд үр өгөөжийн дийлэнх хувийг хүртэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орд баялгаа үнэлэн эзэмших хувь хэмжээг тогтоох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 6
Бүгд: 6
0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, “Онтрэ” ашиглалтын талбайг ашиглахад зээлээр бус хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 5
Бүгд: 6
16.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Баяжмалын агууламжийг уурхайн амнаас лабораториор хянан баталгаажуулж экспортод гаргах гэсэн саналыг редакцын засвартайгаар дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Алт, зэс, газрын ховор элементийн үнэ эрс өссөн байгаатай холбогдуулан үнийн өсөлтийн роялтийг Эрдэнэтийн жишгээр тогтоох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 4

Бүгд: 6

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Менежментийн зардлыг зардлаас бус ашгаас тооцох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

5 дугаар саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Ц.Даваасүрэн нар үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн уг саналаа татаж авав. 6 дугаар саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлж, уг саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

7.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Үндсэн хуулийн өөрчлөлтөөр үр өгөөжийн дийлэнхийг иргэд хүртэх нөхцөлөөр стратегийн ордод хөрөнгө оруулалтын гэрээг “Онтрэ” компанитай байгуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

8.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох зарчмыг хангаж байхаар төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох санал боловсруулах гэсэн саналыг редакцын засвартайгаар дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 0

Бүгд: 6

100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх 8 дугаар санал дэмжигдсэн тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлж, 7 дугаар саналаа татаж авсан тул дээрх саналаар санал хураалт явуулаагүй болно.

9.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтын “зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 0
Бүгд: 6
100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, төслийн 1.2 дахь дэд заалтын “зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн бодитоор бууруулах” гэснийг хасаж, “SOFR+3 хувиас хэтрүүлэхгүй байх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 5
Бүгд: 6
16.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Г.Тэмүүлэн нарын гаргасан, Тогтоолын төслийн 1.4 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Монголын талын хүртэх үр өгөөжийг хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан техник, эдийн засгийн үндэслэл /2010 оны анхны тооцооллын дагуу/ нэрлэсэн үнээр 53 хувиас доошгүй байх нөхцөлийг баталгаажуулан холбогдох гэрээнд тусгах, уг хувь хэмжээг 3 жил тутам харилцан хянан үзэх зарчмыг нэвтрүүлж, “Оюу толгой” хариуцлагатай хувьцаат компанийн үйл ажиллагааны жилийн тайланд талуудад ногдох үр өгөөжийн тооцоог тусгайлан тайлагнах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 0
Бүгд: 6
100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Ц.Даваасүрэн нарын гаргасан, “Оюу толгой” компанийн экспортын борлуулалтын орлогыг Монгол Улсын Төв банк болон арилжааны банкуудаар бүрэн дамжуулж хүлээн авдаг болгох гэсэн саналыг редакцын засвартайгаар дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 0
Бүгд: 6
100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

Оюу толгой ордын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа гүний усыг байгаль, экологийн тэнцвэр алдагдуулахгүйгээр зохистой хэрэглэж, усан хангамжийн хэрэгцээнд гадаргын усыг ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

14.Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалтыг нэмэх:

“Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх сэдвийн хүрээнд зохион байгуулсан хяналт шалгалт, нээлттэй сонсголын явцад ил болсон зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу шалгах, шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий прокурор /Б.Жаргалсайхан/, Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/, Тагнуулын ерөнхий газар /П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газар /Ж.Болд/-т тус тус зөвлөсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 0
Бүгд: 6
100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Хянан шалгах түр хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 19 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 37 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 19 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
15 цаг 30 минут.

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Батнайрамдал: Хянан шалгах түр хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг, Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар, Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа, Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан, Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал гэсэн ирцтэйгээр 54.5 хувийн ирцтэй байна.

Хуралдааны ирц танилцуулж дууслаа.

Хянан шалгах түр хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 54.5 хувьтай бүрдсэн тул Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Түр хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хянан шалгах түр хорооноос боловсруулсан “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

“Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн

талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан танилцуулна.

Б.Жаргалан гишүүний микрофоныг нээе.

Б.Жаргалан: Хянан шалгах түр хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулагдсан.

Хянан шалгах түр хороо нь тайлан, санал, дүгнэлт болон түр хорооноос боловсруулсан Улсын Их Хурлын тогтоолын төслөө 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үед хуралдаан даргалагчаас тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлж санал, дүгнэлт гаргах чиглэл өгсний дагуу тус Байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулах, хэрхэн хянах талаар болон хэрэгжүүлээгүй этгээдэд хариуцлага тооцох асуудлыг тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа тогтоолын төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон шийдвэр, ажиллагааны хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн байдлыг нягталж шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах гэсэн заалттай холбогдуулан хэрвээ сонсголын явцад хууль зөрчсөн аливаа үйлдэл тогтоогдвол түр хороо нь тухайн асуудлыг нотлох баримтын хамт хууль хяналтын байгууллагад шилжүүлэх үүрэгтэй бөгөөд ийм нөхцөл байдал тогтоогдсон эсэх талаар, төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох санал боловсруулаад, цааш хэрхэх талаар, үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх замаар тус ордын үнэ цэнийг нэмэгдүүлэх, ашиглалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрхэн сайжруулах талаар, Монголын талын үр өгөөжийн хувь хэмжээ 53 хувиас доошгүй байх гэсэн тооцооллын талаар асууж хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт тогтоолын төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах гэсэн чиглэлийг зарчмын хувьд байх ёстой талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн нэг дэх заалтад тусгагдсан “стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хилийн заагт орших Жавхлант, Шивээ толгой ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон шийдвэр, ажиллагааны хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн байдлыг нягтлах, ашиглалтын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж” гэж өөрчлөн найруулах, Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтад тусгагдсан “стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хилийн заагт орших Жавхлант, Шивээ толгойн ашигт малтмалын тусгай

зөвшөөрөлтэй холбогдсон шийдвэр, ажиллагааны хууль зүйн үндэслэл хуульд нийцсэн байдлыг нягталж, шаардлагатай тохиолдолд” гэсний дараа “тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах” гэснийг хасах, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж говийн усыг үйлдвэрлэлд ашиглаж байгаа асуудлыг эргэн харах, Оюу толгой ордын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг хадгалж, зохистой хэмжээгээр хязгаартайгаар ашиглах, цаашид гадаргын ус хуримтлуулах байдлаар үйлдвэрлэлдээ хэрэглэх гэсэн саналыг тусгах эсэх талаар саналаа илэрхийлсэн бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн зүгээс тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргаагүй болно.

Хянан шалгах түр хорооны эрхэм гишүүд ээ,

Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

О.Батнайрамдал: Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ц.Даваасүрэн гишүүнээр тасалъя. Ц.Даваасүрэн гишүүний микрофон.

Ц.Даваасүрэн: Хөөш. Энэ Хянан шалгах түр хороо чинь өөрийн гэсэн хуультай. Тэгээд хуулийнхаа дагуу байгуулагддаг байхгүй юу.

Тэгэхээр би өмнө нь бас ийм түр хороог ахалж байсан хүний хувьд. Бид 103 дугаар тогтоолыг би одоо жишээлбэл түр хорооноосоо санаачлаад оруулаад, тэгээд түр хорооны хурал дээр харин бусад гишүүд орж ирж санал гаргаж болно. Тэгж оролцох ёстой байхгүй юу.

Яагаад гэвэл түр хороо, дэд хороо, Байнгын хорооны ижил статустай байхгүй юу. Хууль дээр тийм байгаа шүү дээ. Их Хурлын тухай хууль дээр.

Түүнээс биш чиглэл өгөх чинь өөр. Гурван зүйлээр чиглэл өгч болдог. Энэ Байнгын хорооны ижил статус түр хорооны асуудлыг чиглэл өгөөд өөр Байнгын хороогоор хэлэлцүүлэх тийм эрх мэдэл Их Хурлын даргад байхгүй. Би анх удаагаа сонсож байна.

Тэгэх юм бол энэ Хяналт шалгалтын хууль гэж байгуулаад, ингээд түр хороо гэж байгуулаад хараат бус ажиллуулах нөхцөл чинь өөрөө алдагдаж байна шүү дээ.

Их Хурлын гишүүд энд орж ирээд л өөрсдөө тэр санал гаргах шаардлагатай бол орж ирээд л саналаа хийгээд л, хэлэлцүүлэгт чинь оролцоод л ингээд л явах ёстой байхгүй юу.

Тэгэхээр наадах чинь дэгд байхгүй л юм болох гээд. Одоо жишээлбэл Эдийн засгийн байнгын хорооны тэр саналыг бид хэлэлцэх гээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ чинь ямар дэгээр зохицуулагдаад байгаа юм бэ? Би ийм дэг ерөөсөө мэдэхгүй юм байна. Яагаад гэвэл өмнө нь би түр хороо ахалж байсан хүний хувьд ийм зүйлийг ерөөсөө бодож байгаагүй учраас би тэгээд байна.

Хэрвээ ингээд дэгийн жоохон алдаа гаргаад явах юм бол дараа нь наад гарах тогтоол чинь өөрөө бас цэц дээр ч юм уу, маргаантай асуудал үүсэх юм бол хэлэлцэх дэг чинь өөрөө зөрчигдсөн тухай асуудал гарч болзошгүй байхгүй юу.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын Тамгын газраас бас энэ дээр тайлбар хэлэх ёстой байх.

Тэгэхээр Хянан шалгах түр хорооноос тогтоолын төслөө боловсруулаад, бид бас Байнгын хорооны нийтлэг эрхтэй учраас тэр хүрээндээ бид тогтоолын төслөө Улсын Их Хурал руу оруулж уншсан байгаа. Харин тийм.

Тэгээд бид нарт Эдийн засгийн байнгын хороо бол одоо яг мэргэжлийн хамаарах Эдийн засгийн байнгын хороо болон Хянан шалгах түр хорооныхоо хурлаар дахин хэлэлцүүл гэдэг чиглэл өгсөн учраас Эдийн засгийн байнгын хороонд өчигдөр танилцуулаад санал, дүгнэлт авсан. Санал, дүгнэлтээ сая уншсан.

Гэхдээ гишүүдийн саналууд бол зарчмын зөрүүтэй, өөрсдийнх нь гаргасан зарчмын зөрүүтэй саналаар ирж байгаа.

Тэгэхээр өнөөдөр бид гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахаар байгаа.

Улсын Их Хурлын Тамгын газраас энэ дээр Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулах хэрэгтэй. Бас протоколд үлдэх учраас.

Улсын Их Хурлын Тамгын газраас хэн хариулах вэ? Асуулт асуух гишүүн дээр Ө.Шижир гишүүнийг нэмье. Ө.Шижир гишүүний микрофоныг.

Ө.Шижир: Яах вэ, үүнийг би зүгээр тэмдэглэлд үлдээе гэж байгаа юм.

Яагаад гэхээр Оюу толгой Даваасүрэн гишүүн ээ, түр байж байгаарай. Энэ Оюу толгойн Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл дээр Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт гэсэн байгаа юм. Тэгээд Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт дээр нь Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн зүгээс тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй болно” гээд Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь Эдийн засгийн байнгын хороо чинь ямар нэгэн байдлаар санал, дүгнэлт гаргаж байна гэсэн үг. Эдийн засгийн байнгын хороо санал, дүгнэлт гаргаад, магадгүй Эдийн засгийн байнгын хорооны 5 гишүүн санал, дүгнэлт гаргаад энэ тогтоолыг чинь анхны төслөөс нь өөр болгоод оруулаад ирэх боломжийг нээгээд өгсөн байна шүү дээ.

Тэгэхээр нэг бол үүнийг Эдийн засгийн байнгын хороонд буцаагаад энэ санал, дүгнэлтийг нь өөрчлүүлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол энэ чинь хэлэлцээд,

зарчмын зөрүүтэй санал гаргаагүй гэдгийг нь тодотгоод, Байнгын хорооны санал, дүгнэлтээ хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү гээд өгүүлбэр нь дууссан байна. Энэ чинь эргээд маргаан үүснэ.

Тийм учраас Их Хурлын Тамгын газраас хууль зүйн дүгнэлт гаргуулдаг юм уу, яадаг юм. Нэг бол Эдийн засгийн байнгын хороон дээр дахиж хэлэлцүүлээд үүнийг нь өөрчилдөг юм уу, яадаг юм гэдэг ийм асуудал руу орохгүй бол маргаан үүснэ шүү. Энэ чинь хэлэлцээд санал, дүгнэлт гаргасан гэсэн өгүүлбэрээр дуусч байна шүү. Тэгээд хуралдаанаа үргэлжлүүлээд явах нь таны эрх. Би ямар ч байсан үүнийг протоколд заавал үлдээх хэрэгтэй байна.

О.Батнайрамдал: Одоо бүгдээрээ хурлаа үргэлжлүүлнэ. Гэхдээ Хянан шалгах түр хорооны даргын хувьд бас протоколд үлдээмээр байна. Хянан шалгах түр хорооноос, Манайхан бүгдээрээ сонсоцгоогоорой. Улсын Их Хурал руу түрүүчийн долоо хоногт Улсын Их Хурлын тогтоолын төслөө оруулсан. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар оруулсан. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо болон Хянан шалгах түр хороо руу буцаагдсан учраас Эдийн засгийн байнгын хороо.

Улсын Их Хурлын Тамгын газраас зааварчилгаа өгсний дагуу бид бүхэн явж байгаа шүү. Улсын Их Хурлын Тамгын газраас яг албан ёсоор ийм процессоор явна гэдгийг албан ёсоор гарын үсэгтэйгээр өгүүлсэн байгаа. Тэрийгээ авна. Тийм ээ. Авах ёстой. Тэр хүлээгдэж байгаа. Одоохондоо ирээгүй байна.

Тэгээд Улсын Их Хурлын Тамгын газраас өгсөн зааварчилгаа, арга зүйн зөвлөгөөний дагуу өнөөдрийн Хянан шалгах түр хорооны хурлаа бид явуулж байгаа.

Эдийн засгийн байнгын хороо нь санал, дүгнэлт сая танилцуулсан.

Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт танилцуулагдлаа.

Одоо Хянан шалгах түр хорооны гишүүд болон бусад Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй санал удахгүй хураагдана. Түүнээс өмнө гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооноос танилцуулсан санал, дүгнэлттэй холбогдуулан. Ингэж уншихгүй.

Түр хорооны гишүүд болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү.

Тэгье. Хуралдааныг 15 минут түр завсарлая.

16.06 цаг

О.Батнайрамдал: Хянан шалгах түр хорооны хурал завсарлаад дахин орлоо.

17.35 цаг

Бүгдээрээ санал хураалт явахаас өмнө Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга ирсэн тул тайлбар аваад тэгээд санал хураалт руугаа орьё. Урьд нь хэлчихсэн л байгаа л даа. Өлзийсайхан дарга аа та аль микрофоноос орох вэ? Өлзийсайхан даргын микрофоныг өгөх үү? Асуудал бол Өлзийсайхан дарга аа сая таныг ирэхээс өмнө энд хэд хэдэн гишүүд ярилцаад Хянан шалгах түр хорооны Улсын Их Хурлын тогтоол Улсын Их Хуралд ямар ч байсан тайлан, санал, дүгнэлттэйгээ ороод тэгээд буцаад Хянан шалгах түр хороо Эдийн засгийн байнгын хороо руу буцаагдсан байгаа.

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хороо өчигдөр хуралдаад санал, дүгнэлтээ гаргаад өнөөдөр Хянан шалгах түр хорооны хурлаар танилцуулагдаж уншигдсан байгаа. Тэгэхээр яг энэ Дэгийн хуультай болон холбогдох хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа талаар гишүүд асуугаад байсан л даа. Тэгэхээр энэ дээр та нэг мөсөн тайлбар өгөөд тэгээд үргэлжлүүлэх нь зүйтэй гэж бодож байна. Өлзийсайхан даргын микрофоныг өгье.

Л.Өлзийсайхан: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 55 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт бол түр хороо нь сонсголоор цуглуулж шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн гаргасан сонсголын тайлан, санал, дүгнэлт шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд танилцуулна аа гэж ингэж хуульчилсан байгаа. Тэгэхээр энэ 55.1 дэх хэсэгт заасны дагуу түр хороо бол 2025 оны 12 сарын 19-ний өдөр нэгдсэн хуралдаан дээр танилцуулсан.

Тэгэхээр нэгдсэн хуралдаанаар танилцуулах явцад бол Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс хэд хэдэн асуудлыг тавьсан байгаа.

Нэгдүгээрт, Улсын Их Хурал өөрөө Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлд бол Улсын Их Их Хурал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу сонгогдсон 126 гишүүнээс бүрдэх бөгөөд энэ бүрэлдэхүүнийг Улсын Их Хурлын нийт гишүүн гэж ойлгоно гэж заасан байгаа. Тэгэхээр энэ бол түр хорооны тогтоол биш. Энэ бол Улсын Их Хурлын тогтоол учраас Улсын Их Хурлын нийт гишүүд мэдэх эрхээ хангах ёстой. Тэгэхээр ямар тогтоолын төсөл орж ирж байгаа, уг тогтоолын төсөлтэй зайлшгүй танилцах шаардлагатай гэсэн нэг үндэслэл яригдсан бол байгаа.

Хоёр дахь үндэслэл нь бол уг тогтоолын 1 болоод 2 дахь заалтаар энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг цаашид холбогдох Байнгын хороо буюу Эдийн засгийн байнгын хороонд үүрэг болгож ингэж өгсөн ийм 2 заалт байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болоод холбогдох хууль тогтоомжуудаар түр хороо бол Улсын Их Хуралд энэ түр хорооны тайлангаа танилцуулснаар үйл ажиллагаа ингээд дуусгавар болох дуусах, дуусах ийм хуультай байгаа. Тэгэхээр холбогдох Байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо энэ түр хорооны Улсын Их Хурлын тогтоолд, хэрэгжилтэд хяналт тавих учраас холбогдох Эдийн засгийн байнгын хорооны гишүүд бол уг тогтоолын төсөлтэй танилцаж холбогдох санал, дүгнэлтээ гаргах нь өөрөө Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн холбогдох заалт буюу 45.2, мөн Улсын Их Хурлын бүрэн эрхтэй зөрчилдөхгүй ээ гэж үзсэн. Ийм учраас бол холбогдох Эдийн засгийн байнгын хороо хэлэлцээд санал, дүгнэлтээ гаргасан байгаа. Уг санал, дүгнэлтэд

ямар нэгэн зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд уг санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороо гаргасан боловч уг санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдэх эрх нь өөрөө Хянан шалгах түр хороонд бүрэн эрх нь байгаа.

Тийм учраас энэ бүрэн эрхийнхээ дагуу та бүгд Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцээд уг санал, дүгнэлттэй холбоотой асуудлуудыг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудал түр хорооны бүрэн эрхэд хадгалагдаж байгаа. Ийм учраас ямар нэгэн байдлаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болоод Хяналт шалгалтын тухай хуулийг зөрчөөгүй ээ.

О.Батнайрамдал: Одоо тодруулга байхгүй шүү дээ, тодруулга байхгүй шүү дээ. Одоо би яг нөгөө дэгээрээ явна шүү дээ. Харин тийм. Тодруулга. Тэгвэл өөр тодруулга байна уу? Тэгэхээр тодруулах юм бол би нэр авах ёстой юу? Тэгвэл харин тийм. Даваасүрэн гишүүн ганцаараа. Даваасүрэн гишүүнээ та нэр өгчихсөн байсан тиймээ? Тийм тийм. Тэгэхээр яах вэ тэр үед Өлзийсайхан дарга байхгүй байсан учраас хариултаа одоо авъя гэж байгаа шүү дээ тиймээ, ирсэн учраас. Ойлголоо яах вэ би хэлэх гээд байгаа нь нөгөө энэ чинь яг дэгээрээ явах хэрэгтэй шүү дээ бүгдээрээ. Ойлголоо Даваасүрэн даргаа та тэгвэл тодруулчих. Та тэгвэл тодруулах уу? Тодруулах уу та? Би уншнаа танд харуулаадахья. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийн талаар асуулт асуух. Тийм тийм. Даваасүрэн гишүүний микрофон. Тодруулга. Шижир гишүүнийг нэмье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энэ Их Хурлын хяналт шалгалтын түр хорооны хуулийг бид нар гаргахдаа бас ингээд нөгөө энэ чинь нөгөө тодорхой асуудлаар нийтийн эрх ашиг, тодорхой асуудлаар гаргаж байгаа учраас хараат бус байдлыг нь хангах чиглэлээр нэлээн анхаараад жишээлбэл цөөнхийн гишүүн орж ирэх юм бол Байнгын хороо тэндээ хяналт тавихгүй шүү, Байнгын хорооны өгсөн эрх дээр ямар эрх өгсөн гээд тэгэхээр Байнгын хороо бол хэрвээ эд нар хязгаараасаа давсан асуудал хөндөх гээд тэр нь Үндсэн хуулийн зөрчилтэй байх юм бол Байнгын хороо тэрийг зогсоож болно энэ тэр гэсэн эрхүүдийг нь өгсөн байхгүй юу. Тэрнээс биш одоо ингээд шийдвэрийн төсөл оруулаад ирэхээр нь Байнгын хороо тэр чинь ашиг сонирхлын зөрчилтэй болчих гээд байгаа байхгүй юу. Та нар энийг хэрэгжүүлж ажилла гэж байхад нь урдаас бид нар энийг чадахгүй ээ гээд сууж байж болохгүй шүү дээ.

Тийм учраас наадах чинь тийм зөв тайлбар биш. Яагаад гэвэл өөрөө тэр хяналт тавих чинь Байнгын хороо байгаад байгаа байхгүй юу. Нэг талаараа энэ чинь тодорхой асуудлаар.

О.Батнайрамдал: Нэмэлт 1 минут.

Ц.Даваасүрэн: Бие даасан хуулиар наадах чинь зохицуулагдсан эд байгаа. Тэгэхээр цаашдаа ийм зөрчил гарч магадгүй. Одоо ингээд Байнгын хороонд ингэж чиглэл өгөөд ингээд очдог энэ чинь ноцтой ноцтой асуудлууд их явна шүү дээ. Цаашдаа энэ хяналт шалгалтынх юм чинь тодорхой асуудлаар. Гэтэл Байнгын хороо нь нөгөө гаргах гэж байгаа шийдвэрийг нь тэс өөрчилдөг ийм юм энэ тэр рүү явчих юм бол энэ Хяналт шалгалтын хууль чинь яг тэр бүрэн утгаараа хэрэгжих боломжгүй болно. Бие даасан, хараат бус байдлаар энэ дээр санал, дүгнэлт ээ гаргаад ингээд явах боломжгүй болно. Энэ дээр нэг ийм юм харагдаад байгаа байхгүй юу. Манай дэгийн хуулиуд дээр ингэж байгаа юм.

Санал, дүгнэлтийг танилцуулна. Санал, дүгнэлт гаргана, санал, дүгнэлт оруулна, санал, дүгнэлт хэлэлцүүлнэ. Ингээд утгагүй болгоод хаячихсан байгаа. Яаж ч тайлбарлаж болно. Танилцуулна гэдгийг ч яаж ч тайлбарлаж болно. Тэгэхээр ийм байдал чинь өөрөө энэ хяналт шалгалтын хууль дээр жоохон тийм цаашдаа буруу жишиг тогтоох гэж байна шүү гэдгийг анхаарахгүй бол та нар тодорхой шийдвэрийн төсөл оруулаад ингээд хэлэлцүүлдэг байдал бол эргэлзээтэй болж эхлэх нь ээ гэдгийг би бас тэм.../минут дуусав./

О.Батнайрамдал: Өлзийсайхан дарга хариулъя.

Л.Өлзийсайхан: Даваасүрэн гишүүнтэй санал нэг байна. Яагаад вэ гэвэл яг энэ танилцуулна гээд одоогийн яг энэ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 55.1 дүгээр зүйлд бол холбогдох шийдвэрийн төслийг Улсын Их Хуралд танилцуулна аа гэж байгаа. Тэгэхээс юу гэдэг юм хэлэлцэж шийдвэрлэнэ ээ гэсэн бол ийм үг байхгүй. Диспозиц байхгүй. Тэгээд энэ танилцуулна аа гэдэг нь өөрөө яг ямар нэр томъёо юм бэ? Хууль зүйн хувьд. Тэгэхээр үүнийг Монгол хэлний тайлбар толь болоод яг хууль зүйн тайлбар толь бичгүүдээс харсан. Яг Даваасүрэн гишүүний хэлж байгаатай санал нэг байна. Энэ танилцуулга гэдэг үйл үгийг танилцах гэсэн үйл үгийн үйлдүүлэх хэв гээд, түүний хэл зүйн утгыг юмны учир байдлыг ойлгох, мэдэрч авах, учир байдлыг мэдэх гэжээ гээд.

Тэгэхээр Улсын Их Хурлаас өөрөө 126 гишүүнээс бүрдэнэ. Тэгэхээр Улсын Их Хурлын түр хорооны гаргасан тогтоолын төсөлтэй яасан бэ гэвэл танилцсан. Ингээд Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө санал гаргах бүрэн эрхтэй учраас яг одоогийн энэ дагаж мөрдөж байгаа хүчин төгөлдөр хуулиар бол яг энэ хуулийн заалтынхаа дагуу бол энэ процесс үйл ажиллагаа явж байгаа. Харин цаашид Даваасүрэн гишүүний хэлдгээр яг энэ дээр танилцуулга, хэлэлцэж шийдвэрлэх гэсэн эдгээр асуудлуудыг анхаарах. Оруулна тийм.

О.Батнайрамдал: Шижир гишүүн асууя.

Ө.Шижир: Өдөр ийм маргаан болсон Өлзийсайхан дарга аа.

Нэгдүгээрт өчигдөр тантай Батнайрамдал дарга, Жаргалан гишүүн 2 уулзаад яг энэ үүсээд байгаа энэ дэгтэй холбоотой үүсээд байгаа маргааныг албан бичгээр өгнө өө гэсэн гэж таныг хэлсэн гээд албан бичиг нь байхгүй байна аа гэдэг нэг маргаан үүссэн юм.

Хоёрдугаарт, Эдийн засгийн байнгын хорооноос ирсэн тэр санал, дүгнэлт гэсэн бичиг нь албажаагүй байна аа энийгээ албажуулаа гэдэг ийм маргаан үүссэн. Одоо миний олсон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт нь араас нь албажиж ирж байна. Тэгэхээр миний хэлж байгаа юм бол юу вэ гэхээр араас бичиг ирнэ, араас албажуулна гэдэг байдал ямар ч асуудал байж болохгүй. Дан ялангуяа төрийн байгууллагууд дээр. Тэгэхээр энийг Их Хурлын Тамгын газар анхаармаар байгаа юм. Нөгөө талд нь Хянан шалгах түр хорооноос гаргасан энэ Их Хурлын тогтоол дээр, 2 дээр нь энэ тогтоолыг хэрэгжилтэд Эдийн засгийн байнгын хороо хяналт тавина аа гэххэж байгаа байхгүй юу. Эдийн засгийн байнгын хороо хяналт тавина гэнгүүтээ буцаж орохдоо Эдийн засгийн байнгын хороон дээр ямар нэгэн санал, дүгнэлт хэлэлцсэн болоод зарчмын зөрүүтэй санал гараагүй л болохоос биш гарвал яах юм гэдэг асуудлыг бид нар энд заавал тусгаж өгөх ёстой болчхож байгаа юм.

Хэрвээ гаргаад миний 1 минутыг нэмээд өгчхөөч. Тэгэхдээ Өлзийсайхан дарга цаг бол.

О.Батнайрамдал: Шижих гишүүнд нэмэлт 1 минут.

Ө.Шижир: Тийм дэг байхгүй шүү. Нэг нь нэмэгдэж явдаг, нэг нь хасаж явдаг дэг байхгүй шүү. Тэгээд энэ дээр болохоор Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт дээр болохоор зарчмын зөрүүтэй санал гараагүй болно гэгчхээд Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье гэж байгаа байхгүй юу. Ийм дүгнэлттэй байгаа юм.

Тэгэхээр магадгүй хэн нэгэн гишүүн Эдийн засгийн байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад түр хорооноос гаргасан энэ тогтоол өөрөө танигдахын аргагүй болоод ирэх ийм хууль, эрх зүйн боломж нээлттэй байгаа юм. Ийм болгоод байх юм бол түр хянан шалгах хороо байх шаардлага яг бодитоор байгаа юу гэдэг асуудал байхгүй юу. Энэ чинь хараат бусаар үйл ажиллагаа явуулаад тогтоол гарах ёстой шүү дээ. Тийм учраас нэгдүгээрт миний өдөр асуугаад байсан юм нь Хянан шалгах түр хороонд ирсэн Эдийн засгийн байнгын хорооны энэ тогтоол албажаагүй байна аа. Санал, дүгнэлт чинь албажаагүй байна аа энийгээ албажуул аа.

Хоёрдугаарт, өчигдөр та хэдийн уулзалт протоколгүй болсон юм байна аа. Протоколгүй болсон юм чинь 3 хүний хоорондох яриа болж байна аа. Тийм учраас Улсын Их Хурлын Тамгын газраас энийгээ албажуулж явуул аа гэж байгаа юм. Одоо энэ хоёр хоёулаа албажиж ирсэн үү гэж асуумаар байна Батнайрамдал даргаа? Одоо саяын 2 юм чинь хоёулаа албажиж ирсэн үү? Өдрийн маргаан.../минут дуусав./

О.Батнайрамдал: Өлзийсайхан дарга хариулъя.

Л.Өлзийсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя аа.

Тэгэхээр Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт албажаагүй та бүгдэд танилцуулсан байна. Үүнийг би мэдсэн. Өмнө нь Улсын Их Хурлын Тамгын газарт ийм үйлдэл гарч байгаагүй. Өнөөдөр гарсан байна. Би холбогдох албан тушаалтнуудад хуралдааны тэмдэглэлд тусаж байгаа би хариуцлага бол тооцно.

Хоёр дахь асуудал бол тийм ээ. Өчигдөр холбогдох түр хорооны ажлын хэсгийн ахлагч, дарга болоод мөн Жаргалан гишүүн нартай уулзаж ярилцсан байгаа. Одоо бол би яаж байна вэ гэвэл Хянан шалгах түр хорооны хуралдааны тэмдэглэлд тусгуулж өөрийнхөө албан ёсны хариултыг өглөө. Одоо үүнийгээ би гараад яг тэмдэглэлийн дагуу хуралдааны тэмдэглэлээ би албажуулаад та бүгдэд өгье өө.

О.Батнайрамдал: Жаргалан гишүүнийг нэмье. Жаргалан гишүүний микрофон.

Б.Жаргалан: Энэ Оюу толгойн хянан шалгах түр хороо бол 126 гишүүнтэй парламентаас анх удаа байгуулсан ийм түр хороо ажиллаж байгаа. Мөн Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд анхны энэ түр хороо

үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ талаар өчигдөр бид нар тантай уулзахдаа хэлээд энэ бол маш чухал, чухал тийм прецедентүүдийг тогтоох учраас маш их анхааралтай явах ёстой шүү гэдэг талаар ярьсан байгаа. Тэгээд саяын таны үндэслэл, тайлбар дээр болохлоор нэг зүйл их ойлгомжгүй санагдлаа. Би тэрийг залруулахыг хүсэж байна.

Холбогдох хуулиудаараа бол Хянан шалгах түр хороо Байнгын хорооны нийтлэг эрхүүдийг эдэлнэ. Та тэгэхээр болохоор 55.1 дээр Улсын Их Хурал тогтоолын төсөл танилцуулаад тэгээд бараг эрх, үүрэг нь дуусчхаж байгаа бололтой юм ярьж байгаа байхгүй юу. Гэтэл энэ тогтоолын төсөл танилцуулаад батлагдах хүртэл явах нь түр хорооны эрх гэж ойлгож байгаа. Байнгын хорооны эрх эдэлж байгаагийн хүрээнд.

Тэгэхээр сая одоо жишээлэх юм бол Улсын Их Хурал.../минут дуусав./

О.Батнайрамдал: Жаргалан гишүүнд нэмэлт 1 минут.

Б.Жаргалан: Улсын Их Хурлын чуулганд тогтоолын төслөө танилцуулаад тэгээд Байнгын хорооны тогтоол ордог дэгээр тэр 45.2-оос авхуулаад явж байгаа дэгээр буцаагдсан. Тэгээд манай түр хороо руу буцаагдсан байхгүй юу. Тэгээд өчигдөр жишээлэх юм бол тантай уулзсан шалтгаан бол ер нь энэ түр хорооны дэгтэй холбоотой Тамгын газраас энэ түр хороонд олгож байгаа тэр эрх зүйн дэмжлэг, бүх тэр ажлууд маш дутагдалтай хийгдэж байна аа. Энэ дээр тийм алдаа дутагдлууд гарч байна аа гэдэг асуудлыг танд хэлсэн байгаа.

Тэгэхээр энэ бол таны өөрийн чинь асуудал. Түүнээс биш хэн нэгэн хүнтэй хариуцлага тооцоод тэгээд би тэр хүнтэй нь хариуцлага тооцно оо гээд сууж байна гэдэг бол наадах чинь надаа тун зохимжгүй санагдаж байна. Яагаад вэ гэхээр та тэр 4 дэх өдөр өнгөрсөн 7 хоногт чуулганд энэ асуудал танилцагдаад явахад та байгаагүй тээ? Маш олон удаагийн үйлдэл дээр ерөөсөө байхгүй, хангалттай анхаарал тавихгүй.../минут дуусав./

О.Батнайрамдал: Өлзийсайхан дарга хариулъя. Өлзийсайхан даргын микрофоныг. Өлзийсайхан дарга хариулаадахъя эхлээд.

Л.Өлзийсайхан: Гишүүний асуултад хариулъя. 5 дахь өдөр би хүндэтгэн үзэх шалтгаантай байсан. Тэр бол зайлшгүй. Тийм учраас би нэгдсэн хуралдаанд сууж чадаагүй. Холбогдох эрх бүхий албан тушаалтанд би танилцуулж холбогдох би зөвшөөрлөө авсан байгаа.

Хоёрт нь магадгүй сая шууд утгаар та бүгд ойлгочих шиг боллоо. Би тогтоолын төслийг оруулаад дээрээс нь тайлангаа сонсгоод хуульд заасны дагуу сонссонд тооцсоноор, тогтоолын төслийг баталснаар түр хороо үйл ажиллагаагаа дуусгавар болгоно гэсэн хуулийн заалт байгаа. Үүний дагуу бүх үйл ажиллагаа процессынхоо дагуу явж байна аа гэсэн үүднээс би тайлбарласан болно.

Дараагийн асуудал нь бол хууль зүйн нэр томъёоны тайлбар. Ер нь бол хуулийг бол.../минут дуусав./

О.Батнайрамдал: Нэмэлт 1 минут.

Л.Өлзийсайхан: Мэдээж хууль зүйн нэр томьёоны дагуу хуульчид тайлбар хийнэ. Бид хууль тайлбарлах эрхгүй. Тийм учраас яг энэ нэр томьёо дээр танилцана гэдэг маань өөрөө яг ямар утгатай юм бэ гэдгийг бол Даваасүрэн гишүүний асуусан асуултад хариулж хэлсэн болно.

О.Батнайрамдал: Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Гишүүд ээ тэгэхээр ер нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга явснаас хойших анхны Хянан шалгах түр хороо ингээд явж байгаа юм. Тэр түр хороо юм. Хянан шалгах гэж тэр үед байгаагүй байсан юм. Тэр одоо ингэхэд тийм түр хороо байсан. Яг зөв зөв. Тийм тийм. Таны түр хороо 23 гишүүнтэй байгуулагдаж байсан тиймээ. Тэр үед түр хороо байж байгаад дараа нь Хянан шалгах түр хороо гэдэг агуулга Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар орж ирсэн. Тэр Хянан шалгах түр хорооны ингээд анхны Жаргалан гишүүний хэлээд байдаг зөв л дөө. Прецедент үүсэж байгаа юм л даа ингээд.

Тэгэхээр бид нар энэ Хянан шалгах түр хорооны 11 гишүүн бол бид нар ч гэсэн анхнаасаа бараг анхны хурлаасаа санаж байна. Яг Жаргалан гишүүн яг анхны хурал дээр яг энийгээ л хэлж байсан. Энэ бид нар прецедент тогтоох учраас анхнаас нь бид нар маш болгоомжтой, маш нухацтай хандаж зөв явах ёстой. Яагаад гэвэл дараа дараагийн Хянан шалгах түр хороо байгуулагдахад анхны явж байсан прецедентээ л харна шүү дээ. Тийм учраас энэ дээр бид нар хуулийн талаасаа биш маш олон талаас нь нухацтай хандаж байсан. Тэгээд ч энэ манай сэдэв Оюу толгой бол өөрөө маш том, маш өндөр ач холбогдолтой сэдэв.

Тийм учраас бид нар энэ дээр маш анхааралтай, маш болгоомжтой, бүх талаас нь бодолцож ярилцаж явсан юм аа. Тийм учраас эндээс гишүүд ч гэсэн одоо эндээс асуулт асуугаад бухимдаад байгаа нь ийм учиртай. Ер нь цаашдаа энэ Хяналт шалгалтын тухай хууль дээр дахиад засварууд орох хэрэгтэй гэдэг нь эндээс харагдаж байна л даа. Тэгээд Хяналт шалгах түр хороо байгуулагдаад тийм олон Байнгын хорооноос санал авах хэрэг байгаа юм уу? Тэгвэл хяналт шалгалт гэдэг асуудал юу болох вэ тиймээ?

Тэгэхээр энийг одоо хуулиар ингээд болж байна, болохгүй байна биш яг маш ойлгомжтой болгох хэрэгтэй. Энэ чинь зарчмын асуудал яригдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зарчмыг цаашдаа энэ Хяналт шалгалтын тухай хууль дээр засвар орох хэрэгтэй гэж бодож байна. Дээрээс нь жоохон яг хяналт шалгалтын энэ 6 сараар ингээд явахад жижигхэн жижигхэн янз бүрийн асуудлууд гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ч гэсэн бид нарт санал, зөвлөмж байгаа. Энийг хэдэн гишүүд бид нар хоорондоо ярьсан байгаа. Ер нь энэ Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль дээр ер нь цогцоор нь жоохон нэмэлт, өөрчлөлтүүд орох цаг нь болсон байна аа.

Орохгүй бол ингээд дараа дараагийн ийм маргаанууд гараад байх юм байна гэж. Тэгэхээр энэ дээр Тэмүүжин гишүүн ч түрүүн хэлж байсан л даа. Энэ Хяналт шалгалтын тухай хуулийн, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулахдаа ямар агуулгаар оруулж байсан, түрүүчийн 5 дахийн болон нэгдсэн чуулган дээр энэ талаар ярьж байсан. Тэгэхээр энэ дээр засварууд орох шаардлагатай гэдэг нь эндээс харагдаж байна аа. Энийг протоколд үлдээе.

Гишүүд асуулт асууж, үг хэллээ. Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо бид нар Хянан шалгах түр хорооны гишүүд болон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулах байгаа.

Одоо тогтоол дээрээ саналуудаа оруулна.

Зарчмын зөрүүтэй санал.

1.Тогтоолын төслийн 1.1 дэх заалт дээр нийтдээ ингээд 5 зарчмын зөрүүтэй санал ирсэн байгаа юм. Тэгэхээр энэ санал бүгдээрэнд нь та бүхэнд уншигдаж танилцуулагдаад тэгээд хураагдахаар байгаа. Та бүхэн маань анхааралтай сонсоорой, тараагдсан байгаа.

Эхний 1.1 дэх эхний санал зарчмын зөрүүтэй санал.

Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтын “шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авах” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц, Уянга. Байж байгаарай бүгдийг нь эхлээд унших юм байна.

Дараа нь Даваасүрэн гишүүний 4 зарчмын зөрүүтэй санал байгаа.

Үгүй ээ энэ чинь бүгд 1.1 дээр гарчихсан саналууд бүгд танилцуулагдаад тэгээд дарааллынхаа дагуу явах юм. Зарчмын зөрүүтэй санал.

Дараагийн 4 саналаа Даваасүрэн гишүүн та танилцуулах уу, эсвэл би унших уу эндээс? Саналаа уншихъя ямар ч байсан. 2 дахь.

Даваасүрэн гишүүний эхний санал. Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу иргэд үр өгөөжийн дийлэнх хувийг хүртэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орд баялгаа үнэлэн эзэмших хувь хэмжээг тогтоох.

Хоёрдугаарт, Зээл, Онтрэ ашиглалтын талбайг ашиглахад зээлээр бус хөрөнгө оруулалт FTI санхүүжүүлэх.

Дараагийн Даваасүрэн гишүүний 2 дахь санал. Менежментийн зардлаас бус ашгаас тооцох.

Гурав дахь санал. Баяжмалын агууламжийг уурхайн амнаас лабораториор хянан баталгаажуулан экспортод гаргах.

Хоёр дахь нь. Алт, зэс, газрын ховор элементийн үнэ эрс өсөж байгаатай холбогдуулан үнийн өсөлтийн роялтийг Эрдэнэтийн жишгээр тогтоох.

Дөрөв дэх санал. Үндсэн хуулийн өөрчлөлтөөр үр өгөөжийн дийлэнх нь иргэд хүртэх нөхцөлөөр стратегийн ордод хөрөнгө оруулалтын гэрээг “Онтрэ” компанитай байгуулах гэсэн саналууд байна аа.

1.1-ийн эхний зарчмын зөрүүтэй санал.

Уянга, Лувсанжамц гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар нэмэлт тайлбар хийх үү? Тэгье. Уянга гишүүний микрофоныг өгье.

Б.Уянга: Зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая. Жавхлант, Шивээ толгойн ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ер нь яг энэ сонсгол болох үндсэн шалтгааны нэг нь болохоор Батнайрамдал гишүүн өөрөө анх санаачилгыг гаргаад явж байхдаа нэг зүйлийг их тод ярьсан юм аа. Тэр нь Монгол Улсын Засгийн газар Улсын Их Хуралд мэдэгдэхгүйгээр стратегийн ач холбогдол бүхий ордын тусгай зөвшөөрлийг 2 компани хоорондоо шилжүүлэх гэж байна аа гэсэн агуулга байсан.

Энэ маань болохоороо Ашигт малтмалын тухай хуультайгаа холбоотой асуудал бол байсан. Тэгэхээр энэ тогтоол маань өөрөө Засгийн газар руу өгөгдөхдөө Засгийн газрын эрх хэмжээнийх нь хүрээнд бид нар даалгавар өгөх ёстой. 1.1 дээр болохоороо ер нь энэ Жавхлант, Шивээ толгой ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой шийдвэр, ажиллагаа нь хууль зүйн үндэслэлтэй юм уу, хуульд нийцсэн юм уу гэдгийгээ нягтлаадаа аа. Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуул аа гээд Засгийн газарт өгч байгаа үйл ажиллагаа байгаа.

Ер нь бол аливаа стратегийн ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээг Улсын Их Хуралд танилцуулахгүйгээр хийх боломж байхгүй ээ. Ашигт малтмалын тухай хууль өөрөө тийм ээ. Өглөө бол яах вэ яг албан ёсоор танилцуулгыг бол сонсоогүй, ирж амжихгүй байсан учраас мэдээллүүдийг авахад 11.1.5-ыг бол энэ Засгийн газрын эрх, үүрэг юм аа, яамны эрх, үүрэг юм аа гэдгээр нь бол танилцуулсан билээ. Ашигт малтмалын тухай хуулийг яг нарийн уншаад тэр заалтыг нь унших юм бол хэрвээ тусгай зөвшөөрлийг цуцлах тохиолдолд яг тэр процессыг нь ил тод, нээлттэй байлга аа гэсэн тэр заалт бол байдаг. Тэгж яг практик дээрээ бууж ашиглагддаг заалт бол тэр юм байгаа юм.

Стратегийн ашигт малтмалын ордтой холбоотой бүх харилцаа Улсын Их Хурлын мэдэлд ирчихдэг учраас хэрвээ ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүртэл асуудал үүсэх тохиолдолд тэр бол Улсын Их Хурлын гишүүдийн эрх мэдэл болно. Тэгэхээр энэ дээр ядаж бүгдээрээ 1.1 дээр оруулахдаа тэртээ тэргүй Үндсэн хуулиа бид нар хангуул аа гээд сая Даваасүрэн гишүүний гаргасан саналуудтай бол санал нэгдэж байна. Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуул аа гэж байгаа тохиолдолд нэлээн нарийн судлахгүйгээр иймэрхүү байдлаар өгүүлбэрийг оруулах нь илүүц юм аа гэдгээр саналыг гаргасан юм. Эдийн засгийн байнгын хороон дээр өчигдөр бол хэд хэдэн гишүүд энэ саналыг хэлсэн. Яг өнөөдөр бол яг баталгаажуулаад зарчмын зөрүүтэй саналын хуудас дээр бол Лувсанжамц бид 2 гарын үсэг зурлаа. Өөр бас бусад гишүүд яг энэ саналыг илэрхийлж байсан нь М.Энхцэцэг гишүүн байлаа. Энх-Амгалан гишүүн байсан. Тэгээд бас нэмэлтээр бас холбогдох саналуудыг нь нэмээд гарын үсэг зуруулах бүрэн боломжтой гэдгийг хэлье.

О.Батнайрамдал: Лувсанжамц, Уянга гишүүн нарын гаргасан саналын томъёоллыг. Байхгүй шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал дээр байхгүй шүү дээ. Зарчмын зөрүүтэй саналыг зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн л тайлбарлах эрхтэй байгаа. Дэмжье гэсэн саналын томъёоллоор, үгүй ээ харин тийм шүү дээ.

Тийм тэгэхээр Уянга, Лувсанжамц гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Бэлэн байна. Санал хураалт.

Нийт гишүүдийн “0” хувь дэмжсэнээр санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Баярлалаа. Даваасүрэн гишүүн та саналаа тайлбарлах уу? Эсвэл шууд хураах юм уу та өөрөө л мэд. Тэг харин тийм. Үгүй үгүй. Зарчмын зөрүүтэй санал гаргасан Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Би тайлбарлах уу 1, 1-ээр нь явах уу? 1, 1-ээр нь явъя. Тэгэхгүй бол болохгүй шүү дээ.

Эхнийх нь бол ингэж байгаа юм би. Бидний гаргасан алдаа ерөөсөө ингээд баялгаа үнэлээгүй байхгүй юу. Тийм учраас миний тэр 1 дүгээр заалтдаа та нар ийм агуулгыг оруулчаах ээ л гэж байгаа юм. Баялгаа үнэлээд үр өгөөжийн дийлэнх нь Үндсэн хуулийн дагуу иргэд хүртэх нөхцөл бүрдсэн байхаар эзэмших хувь хэмжээг тогтоох заалт оруулаач, агуулга оруулаач ээ л гэж байгаа юм. Баялгаа үнэлье, тэгээд Үндсэн хуулийн дагуу үр өгөөжийн дийлэнх нь иргэд хүртэж байх тийм хэмжээний хувь хэмжээг тогтоож өгөөч ээ л гэж байгаа юм.

О.Батнайрамдал: Зарчмын зөрүүтэй 2 дахь санал Даваасүрэн гишүүний эхний саналаар. Харин тийм хураах гэж байна шүү дээ. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Бүгдээрээ бэлэн байна. Санал хураалт.

Хуралдаанд оролцсон гишүүдийн “0” хувь дэмжсэн тул санал дэмжигдсэнгүй ээ.

Даваасүрэн гишүүний 2 дахь санал. Онтрэ ашиглалтын талбайг ашиглахад зээлээр бус хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх тээ? Даваасүрэн гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая.

Ц.Даваасүрэн: Би бол нэгдүгээрх заалтыг бол та нар ингэж ойлгож байгаа шүү дээ. Онтрэ дээр шинээр хөрөнгө оруулалтын гэрээ хийх нь ээ гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр тэр хөрөнгө оруулалтын гэрээг хийхдээ ийм ийм зүйлүүдийг анхаараач ээ гэдэг би саналыг хураалгаад байгаа байхгүй юу. “Investment”, “lending” 2 чинь өөр байхгүй юу. Энэ чинь хөрөнгө оруулагч “investor”. Тийм учраас энэ чинь хөрөнгө оруулах, хөрөнгөө оруулаа зээлээр биш шүү гэдэг юмыг заавал. Тэгэхдээ яах вэ та нарын 1 өгүүлбэр байна лээ. Би тэрийг бас зүгээр хэрвээ та нар байгаа гэж үзвэл хөрөнгө оруулалтын санхүүжилтийг гээд нэмээд өгчихвөл би тэрийг хүлээн зөвшөөрч байна. Тэр нөгөө ямар нэмэлт дарамт авчрахгүй байх, санхүүжилтийг гэхчхэн байгаа биз дээ та нар тээ? Үгүй ээ үгүй хар аа тэр чинь хөрөнгө оруулалтын, манайх биш хар аа тэр ямар нэг үр дагаваргүй хөрөнгө оруулалтын санхүүжилт хийх ёстой байхгүй юу тэд нар. Тэд нар хийх ёстой шүү дээ. Тэгээд яах вэ наадах чинь би зээл биш гэж ингэж ойлгоод байгаа юм. Тэгэхдээ хөрөнгө оруулалтын санхүүжилт гэж хэлмээр байгаа байхгүй юу тэгвэл. Үгүй ээ санхүүжилт гэдэг чинь янз бүр байхгүй юу. Санхүүжилт зээл ч орно. Үгүй ээ үгүй зээлээр ерөөсөө хар аа үгүй ээ үгүй “investment” гэдэг чинь “lending” байдаггүй байхгүй юу.

Тэгэхээр харин наадах чинь болохоор санхүүжилт гэхчхээр чинь зээл орчих гээд байгаа юм биш үү? Үгүй ээ үгүй харин тэрийгээ зүгээр яг тэгж ойлгогдох уу? Яах

вэ олон улсын хэллэгээр нь шууд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр гэх ч юм уу нөгөө “Foreign direct investment” гэдгээр нь ч юм уу хэлчхээч гээд байхгүй юу. Хөрөнгө оруулалтын аливаа үүрэг хариуцлага гэдэг чинь манайхыг хэлээд байгаа байхгүй юу. Би биш ээ гадныхыг хөрөнгөө оруулаач гээд байгаа байхгүй юу даа. Санхүүжилт биш. Яах вэ үр дагаваргүй санхүүжилт хий гээд та нар тэгээд байна шүү дээ. Тэгвэл үр дагаваргүй хөрөнгө оруулалтын санхүүжилт гэж бичих гээд байхгүй юу би. Тэгчих юм бол асуудал байхгүй. Нөгөө “investment” хийе гэх гээд байхгүй юу. Би санхүүжилт биш financing биш. Тийм ямар нэг тэгвэл гаднын тал ямар нэг нэмэлт ачаалал, хортой үр дагаваргүй санхүүжилт биш хөрөнгө оруулалтын санхүүжилт “investment”.

Харин тийм үгүй ээ, тэр үр дагавар бүхий гэдгийн ард санхүүжилт гэж байна шүү дээ. Тэгвэл хөрөнгө оруулалтын санхүүжилт гэж хэлбэл болж байна. Биш ээ биш биш. Би Монголын талыг биш гаднын талыг битгий зээл хий гээд байна шүү дээ. “Lending” биш ээ та нар хөрөнгөө оруул. Одоо үр дагаваргүй хөрөнгө оруулалтын санхүүжилт хийх, түүнээс түүнээс гээд явчхаж болно дараагийнхыг нь. Тийм, түүнээс ямар нэг үүрэг хариуцлага хүлээхгүй гэдэг нь манайхыг хэлж байгаа юм.

О.Батнайрамдал: Энэ дээр сая Даваасүрэн гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлалаа. Ер нь бол цаашдаа энэ дээр хөрөнгө оруулалт хийхдээ зээлээр бус илүү хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нь зөв өө гэсэн гэдэг агуулгаар байна. Гэхдээ яах вэ энэ бид нарын уул нь бол яг таны наадах тайлбараа тайлбарлаад байгааг бодож энэ агуулгыг энэ дээр нөхцөлийг нь бүрдүүлэх гэдэг агуулгаар л оруулсан л даа.

Тэгээд Даваасүрэн гишүүний зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

16.7 хувийн гишүүд дэмжсэнээр санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал Даваасүрэн гишүүний санал байгаа 1.1 дээр адилхан. 1.1 дээр Даваасүрэн дарга аа Баяжмалын агууламжийг уурхайн амнаас лабораториор хянан баталгаажуулж экспортод гаргах. Дараагийнх нь бас хамт явах уу үгүй юу хамт явчихаар л байна. 1,1-ээр Зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая Даваасүрэн гишүүний микрофон.

Ц.Даваасүрэн: Одоо ингээд ТЭЗҮ-г 5, 5-н жилээр ингээд шинэчилье гээд эд нар чинь тийм Дубайн гэрээгээр юм хийчихдэг шүү дээ энэ чинь аймаар зальтай байгаа байхгүй юу. Энэ чинь яг анхны 2010 оны ТЭЗҮ-гээрээ 22.7 сая зэс гэж байгаа шүү дээ, 1800 тонн алт. Одоо тэгсэн чинь 243 тонн алт, 8 сая зэс болгочхож байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл өрөм хэсгийг нь аваад л хаях гэж байна шүү дээ. Тэгээд энэ чинь нураадаг технологиор хийж байгаа учраас тэр километрийн гүнээс бид нар дараа нь ашиглаж чадахгүй болчихно.

Тийм учраас миний наана чинь хэлээд байгаа нь эд нар ерөөсөө тийм 1800 хүн мянган алт гаргах гэж байгаа нь бид нарт ямар ч хяналтгүй байгаад байгаа одоо. Яагаад гэвэл нөхдүүд ингэж байгаа юм байна лээ. Би өөрөө очиж үзсэн хүний хувьд хэлж байгаа шүү. 3 шуудай өөрсдөө бэлдчихэж байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг нь манай гаалийн лабораториор оруулаад явчхаж байгаа юм. Гэтэл нөгөө бид нар цаана нь 1800 биш 240 хэд болчихоод байна шүү дээ. 1000 тонн алт гэдэг бол

агууламжийн хувьд алдаж байгаа байж магадгүй шүү дээ. Хянаж чадахгүй байгаа учраас. Тийм учраас ер нь бид нарын нэг гол хийх ёстой юм бол энэ шүү. Ямар хэмжээний алт, ямар хэмжээний газрын ховор элементүүд гарч байгаагаа заавал бүртгэлтэй байлгах хэрэгтэй. Энийг бол бүр хатуу хийх хэрэгтэй тэр шинэ гэрээндээ бол.

О.Батнайрамдал: Даваасүрэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг редакцын засвартайгаар дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нийт гишүүдийн 83.3 хувь дэмжсэнээр зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Дараагийн Даваасүрэн гишүүний санал. Алт, зэс, газрын ховор элементийн үнэ эрс өссөн байгаатай холбогдуулан үнийн өсөлтийн роялтийг Эрдэнэтийн жишгээр тогтоох.

Зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу та?

Ц.Даваасүрэн: Одоо жишээлбэл та нар ингээд хараарай. Сүүлийн татвар төлөлтүүдийг та нар харсан шүү дээ. 200 сая доллароос ерөөсөө хэтрэхгүй байгаа тээ? Бүх татвар нь шүү бүх татвар нь. Гэтэл алтны үнэ 4-өөс 5 дахин өсчихсөн. Зэсийн үнэ 2.6 дахин өсчихсөн. Үгүй ээ тэр үнийн өсөлтийн юм яагаад Монголд орж ирэхгүй байгаа юм гэдэг асуудал байгаа байхгүй юу. Адаглаад тэд нар Монголд оруулдаггүй юм аа гэхэд тэр тэрбум жишээлбэл та нар 11 сарын гаалийн юу аваад үзээрэй. 3 тэрбум доллар олсон байгаа байхгүй юу. Хуучин 2 тэрбум доллар олдог байсан бол. Үгүй ээ тэр 1 олсон 1 тэрбумаараа энэ хөрөнгө оруулалтуудаа санхүүжүүлэхэд яадаг юм, яагаад зээл аваад байгаа юм? Одоо 21 онд Их Хурлаас зээл авч болохгүй гээд шийдвэр гарсан байхад наадуул чинь 3.2 тэрбум долларын зээл авчихсан байгаа шүү дээ. Ингээд бид нар ашигтай болоод ирэнгүүт, үнийн өсөлтөөс ашигтай болоод ирэнгүүт наадуул чинь зээл аваад зардлаа өсгөөд манай ноогдол ашгийг орлогын албан татвар төлөхгүй болчихоод байна шүү дээ тийм ээ? Заалттай тэгсэн мөртөө аваад байна шүү дээ.

Тэгэхээр одоо бид нар байна шүү дээ ерөөсөө энэ роялтийг нь шууд авах хэрэгтэй. Тогтоол гаргаад биелүүлдэггүй юм байна. Тийм учраас ерөөсөө одоо ингээд л роялти аваад л Эрдэнэт шиг авчих хэрэгтэй. Тийм гэрээн дээр харин тийм шүү дээ. Би “Онтрэ” дээр та нарыг би шинэ гэрээ хийнэ гэж шийдвэр гаргана гэж бодоод байна шүү дээ. Тэгээд тэр гэрээндээ бол үнийн өсөлтийн хориотой Эрдэнэтийн жишгээр авдаг бол оо. Тэгэхгүй бол бид нар тогтоол гаргаад та нар битгий зээл ав гэхээр аваад байна шүү дээ. Гэтэл та нар бод доо. Үгүй ээ үгүй одоо бид нар шинэ гэрээ байгуулах тухай тогтоол гарч байгаа байхгүй юу хамгийн гол нь. Үгүй ээ бод л доо 4 дахин алтны үнэ 5 дахин өсчхөөд байхад чинь татвар нь хэвээрээ байна гэж яаж байж болох юм бэ? Зэсийн үнэ нь 11, одоо бараг өнөөдөр 12, 3 болчихсон байгаа байх. Болохгүй шүү дээ. Тийм учраас өсөн нэмэгдэх роялти авахаас өөр арга байхгүй.

О.Батнайрамдал: Даваасүрэн гишүүн нэмэлт тайлбар.

Ц.Даваасүрэн: Одоо байгаа роялтигийн хэмжээг нь би хэлээд байгаа байхгүй юу. Зүгээр хар аа та нар нэг юм анхаараарай. Яг ингээд Оюу толгой хөрөнгө оруулалтын гэрээ хийхийн хувьд 6 хуульд өөрчлөлт оруулсан байгаа шүү дээ

наадуул чинь. Тийм учраас бид нар Онтрэ-гийн гэрээг хийхийн тулд бас хуулиуддаа өөрчлөлт хийж болох байхгүй юу. Ашигт малтмалын хуульдаа тэр 34 хувийг ч бид нар өөрчилж болно шүү дээ. Өөрийн чинь хэлээд байгаа шиг роялтиг ч өөрчилж болно. Зүгээр Эрдэнэтийн тэр 18 гээд байгаа чинь ер нь болбол олон улсын жишиг. Хамгийн бага Перу 12, манайх бол өшөө 5 болчхоод бүүр доошоо явчихсан шүү дээ. Тэр нөгөө Замби хавь руу явчихсан. Чили бол 18 хувь. Тэгэхдээ яг Чилийн тэр жишгээр л Эрдэнэтээр тогтсон юм байна лээ.

О.Батнайрамдал: Даваасүрэн гишүүний ингээд 4 дэх санал тээ? 4 дэх саналаар тэгээд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

33.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал Даваасүрэн гишүүний 5 дахь санал. Энэ би зөв уншиж байна уу? Менежментийн зардлыг зардлаас бус ашгаас тооцох тээ? Та зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу?

Ц.Даваасүрэн: Би бол 1 дүгээр заалтаар та нарыг Онтрэ-тай шинээр байгуулах гэрээнд чиглэл өгөх гэж байгаа гэж ойлгож байгаа шүү. Тийм учраас одоогийн гол алдаа юу ерөөсөө л энэ чинь зээл аваад л зардал өсгөөд л зээл төлдөг компани болгочихсон байгаа шүү дээ. Энэ нь үндэс нь юу юм? Хөрөнгө оруулалтын тэр гэрээнээс гадна хувь нийлүүлэгчдийн гэрээгээр аваачаад менежментийн зардал 6 хувийг зардлаас тооцно. Үгүй ээ энэ чинь удирдлагын баг зардлаа өсгөхийн төлөө ажилладаг байж болохгүй шүү дээ. Тийм учраас л би наад саналыг чинь оруулаад байгаа юм. Би зүгээр хэд хэдэн энэ гэрээ дээр байгаа хамгийн ноцтой гэсэн юмнууд дээр л санал хураалгаад байгаа юм шүү. Роялти авахгүй байна, зээл авч байна, зардлаас удирдлагынхаа багийг энэ чинь байж болохгүй зүйл байхгүй юу.

О.Батнайрамдал: Тийм тийм зөв зөв. Тэгэхээр тэр сая Даваасүрэн гишүүний сая хэлсэн зарчмын зөрүүтэй саналын тайлбар дээр бас нэмээд хэлэхэд сая урьд өмнөх санал хураалт явуулсан өсөн нэмэгдэх роялти ч гэсэн тэр байхгүй гэсэн үг биш шүү. Онтрэ хөрөнгө оруулалт одоо Оюу толгой дээр хүчин төгөлдөр байгаа хөрөнгө оруулалтын гэрээ болон хувь нийлүүлэгчийн гэрээнд хамаарахгүй. Тэн дээр тогтворжуулсан бол тийм юм бол байхгүй ээ. Одоогийн байгаа хууль тогтоомжоор явна гэдэг агуулгаар байгаа гэж үзэж байгаа. Байгаа гэж үзэж байгаа. Өсөн нэмдэг роялти Ашигт малтмалын тухай хуулиараа байгаа. Тийм учраас тэр агуулгаар яг энэ тогтоолын төслийн тэр дээр аль түрүүн орчихсон учраас, санал, дүгнэлт дээрээс орчихсон учраас гэдэг агуулгаар санал хураалт явагдсан байгаа. Даваасүрэн гишүүн бас нэмэлт тодруулгаа хэлчихье.

Ц.Даваасүрэн: Би ингэж ойлголоо шүү. Одоо энэ бол нөгөө хөрөнгө оруулалтын өмнөх гэрээгээр явахгүй. Тийм учраас одоо байгаа Монгол Улсын хууль тогтоомжоороо энэ өсөн нэмэгдэх роялтигийн татварыг бол төлөөд явна гэдэг агуулгаар ойлголоо шүү би. Тэгвэл миний энэ саналыг би татаад авчхаж болж байна. Байгаа гэж агуулгаар.

О.Батнайрамдал: Зөв. Даваасүрэн гишүүн бас маш ойлгомжтой тайлбараа хэллээ. Саналаа гаргасан гишүүн саналаа татсан учраас санал хураалт явуулахгүй.

Дараагийн санал руугаа оръё. Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Тогтоолын төслийн үндсэн агуулга хэсэг дээр энэ удирдлагын багийг ашгаас санхүүжүүлэх энэ заалтыг, энэ агуулгыг бол та нар санал, дүгнэлтдээ оруулчихсан гэж үзэж байгаа юм байна шүү дээ тээ? Тэгээд энэ санал, дүгнэлтийг бол хэрвээ хөрөнгө оруулалтын гэрээ шинээр байгуулагдахад хүрвэл баримтал гээд чиглэл олгочихсон гэж ойлголоо шүү дээ. Тийм бол би энэ саналаа татъя.

О.Батнайрамдал: Даваасүрэн гишүүн саналаа татлаа.

Дараагийн санал Даваасүрэн гишүүний санал.

Үндсэн хуулийн өөрчлөлтөөр үр өгөөжийн дийлэнхийг иргэд хүртэх нөхцөлөөр стратегийн ордод хөрөнгө оруулалтын гэрээг “Онтрэ” компанитай байгуулах гэсэн санал байна.

Даваасүрэн гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлая.

Ц.Даваасүрэн: Энэ та нарын 1.1 байна шүү дээ. 1 дүгээр заалт дээр. Энэ “Онтрэ” компанитай бол хуучин хөрөнгө оруулалтын гэрээгээр явахгүй шүү дээ. Шинэ хөрөнгө оруулалтын гэрээгээр явна шүү дээ гэдэг агуулга яг байгаа юу?

О.Батнайрамдал: Тэгэхээр сая бид Даваасүрэн гишүүний зарчмын зөрүүтэй санал дээр редакцын засвар ороод, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдох зарчмыг хангаж байхаар төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох санал боловсруулах. Мөн энэхүү саналыг редакцын засвартайгаар дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүдээ анхаараарай. Санал хураалт.

Болчихсон, болчихсон. Өмнөх санал. Байж байгаарай, ямар ч байсан байж бай. 100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн учраас 6 дахь саналаа та татах юм байна тийм ээ? Тэгвэл, үгүй ээ тэр саналыг бид найруулсан шүү дээ. Тэгэхээр Даваасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Даваасүрэн: Саяын санал дэмжигдсэн учраас санал давхцаж байгаа учраас би 6 дахь саналыг татлаа.

О.Батнайрамдал: Болсон. Даваасүрэн гишүүнд баярлалаа. Дараагийнхаа санал руу орцгооё. Дараагийн саналдаа оръё.

Тогтоолын төслийн 1.2 дахь хэсэгт 2 зарчмын зөрүүтэй санал байгаа. Эхний саналыг танилцуулъя.

Тогтоолын төслийн 1.2 дахь дэд заалтын “зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн” гэснийг хасах. Зарчмын зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн. Та саналаа тайлбарлах уу? Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

Г.Тэмүүлэн: Түр хорооныхоо гишүүдэд оройн мэнд хүргэе. Энэ дээр би санал гаргаж байгаа асуудал маань яах вэ зүгээр санхүүжилтийн хүүгийн хувь хэмжээг зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн бодитоор бууруулах гэж байсныг нь

үндсэндээ тэр зах зээлийн зарчим болоод жишигт нийцүүлэн гэдэг нь бол өөрөө жоохон учир дутагдалтай, өрөөсгөл ийм томьёолол болж байна гээд байгаа. Тэгээд энийг бол хасъя гэдэг асуудлыг бол ярьж байгаа. Тэгэхээр бид мэдээж үндсэндээ юу гэдэг юм гол үндсэн асуудал маань яриа хэлэлцээ явах ёстой. Яриа хэлэлцээ бол мэдээж бизнесийн зарчим дээр байдаг.

Тэгээд яриа хэлэлцээний хүрээнд энэ төслийг 2 тал хувь нэгж талуудад харилцан ашигтай байдлаар өөрчлөх, тухайн тэр зардлуудыг бууруулах, тэгээд үндсэндээ тэр санхүүжилтийн хүүгийн хувь хэмжээ нь хэд байх нь бол яриа хэлэлцээнээс мэдээж хамаарна. Энэ хүрээнд хийх ёстой л гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр хэдэн хувь бууруулах нь эдийн засгийн тооцоолол болоод яриа хэлэлцээний явцад шийдэгдэх асуудал болохоос биш, одоо бид энийг бол зах зээлийн зарчимд бай, жишигт нийцүүл гэдэг юм уу ийм байдлаар тодорхой юу гэдэг юм цензур тавьж яах нь бол буруу юм. Энэ бол эргээд өрөөсгөл ойлголт байна. Тэгэхээр бид энийг үндсэндээ Оюу толгой төсөл зөвхөн үр өгөөжтэй байх, хувь нэгж талуудад харилцан ашигтай байх зарчмын хүрээнд бол тодорхой, бодитоор бууруулаа л гэдэг шаардлагыг шууд тулгах нь зүйтэй л гэсэн ийм шаардлагыг тавьж байгаа юм. Тэгээд ийм байдлаар өөрчлөх нь илүү яриа хэлэлцээний явцад бидэнд хэрэгтэй байна байх гэсэн ийм саналыг гаргаж байгаа шүү.

О.Батнайрамдал: Тэмүүлэн гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал мөн төслийн 1.2 дахь дэд заалтын “зах зээлийн зарчим, жишигт нийцүүлэн бодитоор бууруулах” гэснийг хасаж, “SOFR дээр нэмэх нь 3 хувиас хэтрүүлэхгүй байх” гэж нэмэх. Зарчмын зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж.

Пүрэвдорж гишүүн байхгүй байна. Тэгэхээр Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор, дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нийт гишүүдийн 16.7 хувиар дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Дараагийн зарчмын зөрүүтэй саналыг уншъя. Гишүүд анхаараарай.

Тогтоолын төслийн 1.4 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Монголын талын хүртэх үр өгөөжийг хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдсан техник, эдийн засгийн үндэслэл /2010 оны анхны тооцооллын дагуу/ нэрлэсэн үнээр 53 хувиас доошгүй байх нөхцөлийг баталгаажуулан холбогдох гэрээнд тусгах, уг хувь хэмжээг 3 жил тутам харилцан хянан үзэх зарчмыг нэвтрүүлж, “Оюу толгой” хариуцлагатай хувьцаат компанийн үйл ажиллагааны жилийн тайланд талуудад ногдох үр өгөөжийг тооцсон тусгайлан тооцоог, үр өгөөжийн тооцоог тусгайлан тайлагнах гэсэн саналын томьёолол байна. Зарчмын зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн, Жаргалан.

Яг энэ саналтай бас давхцаад, агуулга давхацсан нэг санал байгаа, хамтдаа унших ёстой байгаа. Тогтоолын төслийн 1.4 дэх заалтын 5 жил тутам харилцан хянан үзэх гэснийг 3 жил тутам харилцан хянан үзэх болгож өөрчлөх, зарчмын

зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болормаа, Зулпхар, Шижир, Жаргалан.

Тэгэхээр эхний саналаар тийм ээ, эхний саналаар Тэмүүлэн, Жаргалан гишүүний гаргасан өөрчлөн найруулах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 100 хувь дэмжсэнээр санал дэмжигдлээ. Дараагийн саналыг уншъя.

1.5 дахь дэд заалт дээр нэмэх.

“Оюу толгой” хариуцлагатай хувьцаат компанийн борлуулалтын орлогыг Монголын арилжааны банк болон Төв банкны дансаар 100 хувь дамжуулж авдаг болох. Зарчмын зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд, Даваасүрэн. Соронзонболд гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу?

Л.Соронзонболд: Одоогийн бид экспортынхоо борлуулалтын орлогын 40-өөс 50 хувийг бол Монгол Улсын арилжааны банк болон Монголын Төв банкны дансаар бол хүлээж авч байгаа гэж мэдээлэлтэй байгаа. Тийм учраас бол ер нь Монгол Улс маань өнөөдөр дотоодын бүтээгдэхүүн маань 90 их наяд төгрөг буюу ойролцоогоор 25-аас 26 тэрбум долларын хэмжээтэй болсон байна. Тийм учраас “Оюу толгой” компани бол ер нь борлуулалтын орлогоо Монголын арилжааны банкаар, банкны системээр дамжуулах ийм боломж бүрдсэн. Тийм учраас ер нь экспортын орлогоо бол Монгол Улсын банкаар дамжуулах шаардлагатай байна гэж үзэж байгаа. Тийм учраас ийм санал гаргасан.

О.Батнайрамдал: Соронзонболд гишүүн тайлбар өгье.

Л.Соронзонболд: Сая ярилцсаны дагуу зарчмын зөрүүтэй санал дээр ийм найруулгын өөрчлөлт хийе гэж оруулж байна. “Оюу толгой” компанийн экспортын борлуулалтын орлогыг Монгол Улсын Төв банк болон арилжааны банкнуудаар дамжуулж хүлээн авдаг, бүрэн дамжуулж хүлээн авдаг болгох гэдэг, дамжуулж авдаг болох гэдэг ийм найруулгын засвар оруулъя.

О.Батнайрамдал: Соронзонболд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дараа нь редакцын засвартайгаар дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Гишүүдийн 100 хувь дэмжигдсэнээр санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Тогтоолын төслийн 1 дэх заалтаар доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

Оюу толгой ордын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа гүний усыг байгаль, экологийн тэнцвэр алдагдуулахгүйгээр зохистой хэрэглэж, усан хангамжийн хэрэгцээнд гадаргын усыг ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан.

Энэ санал бол яах вэ манай 62 дугаар тогтоолоор байгуулсан Хянан шалгах түр хорооны хүрээ хязгаарт бол яг байгаль орчинтой холбоотой асуудал байхгүй юм

л даа. Энэ гэхдээ энэ байгаль орчин, усны хэрэглээтэй холбоотой асуудал бол одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын 92 дугаар тогтоол, 103 дугаар тогтоол дээр бол байдаг.

92 дугаар тогтоолын 5 дахь хэсэгт бол байгаль орчин, усны нөхцөл байдлыг үнэлэн шинэчлэн хийлгэж, говийн ус ашиглах нөхцөлийг харгалзан тогтоох гээд нэлээн том агуулгаар орсон. 103 дугаар тогтоол дээр бас 5 дээр нь “Оюу толгой” хувьцаат компанийн засаглал, биш ээ хаана байна вэ? Тийм, энэ 4 дээр нь Оюу толгой төслийн гүний уурхайд ашиглаж, олборлолт эхлэх, байж байгаарай, энэ хаана байна вэ? Энэ байна. 5 дээр нь нэлээн олон юм дурдагдсанаас цахилгаан эрчим хүчээр хангах, гэрээ байгуулах, ус ашиглалт, байгаль орчин чиглэлээр хамтран ажиллах гээд агуулгаар бол тусчихсан ийм санаа байгаа юм.

Жаргалан гишүүн. Жаргалан гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу? Жаргалан гишүүний микрофоныг өгье.

Б.Жаргалан: Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 92 дугаар тогтоол, 103 дугаар тогтоол дээр энэ усны асуудлыг тодорхой тусгасан байгаа учир энэ саналыг татаад, тэгээд тэр өмнөх 2 тогтоолын хэрэгжилт дээр бас анхаарч ажиллах нь зүйтэй юм байна гэсэн ийм байр суурийг хэлье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Дараагийн зарчмын зөрүүтэй санал. Тогтоолын төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалтыг нэмэх:

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх сэдвийн хүрээнд зохион байгуулсан хяналт шалгалт, нээлттэй сонсголын явцад ил болсон зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу шалгах, шийдвэрлэхийг Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Авлигатай тэмцэх газар З.Дашдаваа, Тагнуулын ерөнхий газар П.Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газар Ж.Болдод тус тус зөвлөсүгэй. Зарчмын зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан.

Мөнхбаясгалан гишүүн та зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлах уу? Микрофон өгье.

Л.Мөнхбаясгалан: Энэ Оюу толгой бүлэг ордыг ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай гээд энэ зарчмын зөрүүтэй санал дээр би өгч байна. Тэгэхээр энэ та бүхний хийсэн энэ сонсголын үр дүнд өнөөдөр Монголын ард түмэн Улсын Их Хурал, Засгийн газар юу мэдэж авсан бэ гэхээр энэ гэрээг байгуулахдаа Монголын эрх ашгийг огт харгалзан үзээгүй. Жишээ нь та бүхний энэ дүгнэлтийн 1 дүгээрт байгаа, хөрөнгө оруулагч талтай гэрээ байгуулах зарчим, удирдамжийг тодорхойлсон Улсын Их Хурлын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны тогтоол, бодлогын баримт бичгүүдийг баримтлан ажиллаагүйгээс болж, Монгол Улсын эрх ашиг өнөөдрийг хүртэл зөрчигдсөн нь бол тодорхой болсон.

Ганцхан тоо хэлэхэд хөрөнгө оруулагчаар “Рио Тинто” 10.1 тэрбум доллар оруулаад, 2037 он гэхэд 31.2 тэрбум доллар авна. Харин Монгол Улс 2037 он гэхэд 25.1 тэрбум долларын өрөнд орох юм. Тэгэхээр би зүгээр Улсын Их Хурлын тогтоол гаргаад орхимооргүй байгаа. Тухайн үед Монгол Улсын эрх ашгийн эсрэг зохион байгуулж, урьдчилан тохиролцсон байж болзошгүй, бүлэглэл үйлдсэн байж болзошгүй, Монгол Улсад хор хохирол учруулах хорлон сүйтгэсэн байж болзошгүй тийм эрүүгийн шинжтэй, хууль зөрчсөн шинжтэй энэ байдлууд тодорхой болсон учраас холбогдох байгууллагуудад зөвлөмж өгч, энэ зарчмын зөрүүтэй санал гаргасан юм. Тэгээд та бүхэн энийг дэмжиж өгөөч.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий прокурор Жаргалсайхан, Авлигатай тэмцэх газрын дарга Дашдаваа, Тагнуулын ерөнхий газрын дарга Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга Болд нарт тус тус зөвлөсүгэй гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал байна.

О.Батнайрамдал: Мөнхбаясгалан гишүүн зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлалаа. Тэгэхээр энэхүү саналыг сая уншсанаар дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нийт гишүүдийн 100 хувь дэмжсэнээр зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн талаарх гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

“Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх түр хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Хянан шалгах түр хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал миний бие уншиж танилцуулна.

Өнөөдөр Хянан шалгах түр хорооны хамгийн сүүлийн хурал байлаа. Хянан шалгах түр хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон болон энэ 6 сарын туршид бид бүхэнтэй хамт байсан Хянан шалгах түр хорооны гишүүн болгонд чин сэтгэлээсээ баярласан, талархсанаа илэрхийлье.

Өнөөдрийн хуралдаан өндөрлөлөө. Баярлалаа.

19.36 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР